58

## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2024/179/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа |
| | Утас:7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn |
| Сүхбаатар сум | Аудитын менежер: Б.Батмөнх |
| 2024 он | Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn |
| | Ахлах аудитор: Ц.Отгонбаяр |
| | Утас: 7036-3047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

59

## Агуулга


1. Аудитын дүгнэлт 3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 5-10

3. Санхүүгийн тайлангийн тодруулга 11-14

   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 11

   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 11

   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 11-12

   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 12-13

   3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 13-14

4. Аудитын тайлан 14-16

   4.1 Ерөнхий зүйл 14

   4.2 Материаллаг байдал 14-15

   4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 15

   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 15

   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 16

   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 16

5. Аудитын илрүүлэлт 16-17

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл 18


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| МУЕП | Монгол Улсын Ерөнхий прокурор |
| МУПЕГ | Монгол Улсын Прокурорын Ерөнхий газар |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.19 № СЭА-2024/179/НА-СТА-ТШ13
танай ______________-ны № ________________-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ХУУЛЬ ЦААЗЫН ШАДАР ЗӨВЛӨХ
Б.ЭРХЭМБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2023 оны нийт зардал өмнөх оноос 12.4 хувиар нэмэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

УПЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу цалингийн зардлын хэмнэлтээс 18,068.0 мянган төгрөгийг УЕПГ-ын 2102983685 дугаар дансанд төвлөрүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

018020021

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

# 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **20,500,612.61** | **14,279,965.61** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **20,500,612.61** | **14,279,965.61** |
| **35400** | **Хангамжийн материал** | **20,500,612.61** | **14,279,965.61** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,682,650.00 | 3,249,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,179,700.00 | 6,430,200.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 69,462.61 | 371,465.61 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,728,800.00 | 4,228,800.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **835,220,842.35** | **791,354,511.77** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **835,220,842.35** | **791,354,511.77** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **830,193,342.35** | **786,657,011.77** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 669,602,340.00 | 669,602,340.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -44,740,098.24 | -55,925,122.80 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 75,800,000.00 | 75,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -27,152,083.48 | -44,877,083.56 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 147,388,290.76 | 159,372,510.76 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -43,160,774.65 | -73,072,549.92 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 81,403,068.81 | 95,200,968.81 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -28,956,400.85 | -39,453,051.52 |
| 39217 | Ном | 9,000.00 | 9,000.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **5,027,500.00** | **4,697,500.00** |
| 39301 | Програм хангамж | 1,320,000.00 | 1,320,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -192,500.00 | -522,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,900,000.00 | 3,900,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **855,721,454.96** | **805,634,477.38** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **855,721,454.96** | **805,634,477.38** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **855,721,454.96** | **805,634,477.38** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 275,943,025.00 | 275,943,025.00 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 275,943,025.00 | 275,943,025.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **549,748,236.44** | **499,661,258.86** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 525,991,114.43 | 549,748,236.44 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 23,757,122.01 | -50,086,977.58 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 30,030,193.52 | 30,030,193.52 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **855,721,454.96** | **805,634,477.38** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **796,473,350.00** | **818,626,820.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **58,767,150.00** | **6,547,420.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **58,767,150.00** | **6,547,420.00** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 58,767,150.00 | 6,547,420.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **737,706,200.00** | **812,079,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **737,706,200.00** | **812,079,400.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 737,706,200.00 | 812,079,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **772,716,227.99** | **868,713,797.58** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **772,716,227.99** | **868,713,797.58** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **734,156,696.74** | **814,554,780.62** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **515,785,029.82** | **569,758,706.14** |
| 210101 | Үндсэн цалин | 313,548,560.56 | 315,231,310.50 |
| 210102 | Нэмэгдэл | 153,640,967.71 | 164,297,640.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 23,205,000.00 | 31,253,000.00 |
| 210104 | Урамшуулал | 25,390,501.55 | 51,477,042.84 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0 | 7,499,712.65 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **62,334,620.36** | **69,288,762.89** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,367,663.90 | 47,228,027.48 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,505,587.71 | 5,556,238.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,601,110.09 | 4,414,190.83 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 896,387.19 | 1,099,118.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,963,871.47 | 10,991,187.25 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **28,998,145.57** | **29,651,746.36** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,619,983.57 | 8,982,243.36 |
| 210302 | Түлш, халаалт | 18,127,784.00 | 15,892,357.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,250,378.00 | 4,777,146.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **36,280,101.00** | **35,406,589.65** |
| 210401 | Бичиг хэрэг | 12,402,738.00 | 11,766,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,586,343.00 | 10,647,897.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,391,570.00 | 4,741,522.65 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 951,000.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,948,450.00 | 8,010,420.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **14,008,300.00** | **15,599,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 13,709,400.00 | 15,599,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,953,800.00** | **7,265,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,953,800.00 | 7,265,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,597,453.00** | **16,627,125.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,000,000.00 | 15,270,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 188,853.00 | 159,225.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,356,800.00 | 1,150,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 7,800.00 | 3,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **62,199,246.99** | **70,957,450.58** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,335,850.00 | 1,309,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 57,302,196.99 | 69,648,450.58 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **38,559,531.25** | **54,159,016.96** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,210,000.00** | **1,950,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,210,000.00 | 1,950,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **37,349,531.25** | **52,209,016.96** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,349,531.25 | 52,209,016.96 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **23,757,122.01** | **-50,086,977.58** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **23,757,122.01** | **-50,086,977.58** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **737,706,200.00** | **813,079,400.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **0** | **1,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **0** | **1,000,000.00** |
| 120009 | Бусад орлого | 0 | 1,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **737,706,200.00** | **812,079,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **737,706,200.00** | **812,079,400.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 737,706,200.00 | 812,079,400.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **718,011,600.00** | **793,844,700.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **718,011,600.00** | **793,844,700.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **679,452,068.75** | **739,685,683.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **515,785,029.82** | **570,758,706.14** |
| 210101 | Үндсэн цалин | 314,161,238.77 | 318,699,992.37 |
| 210102 | Нэмэгдэл | 153,505,937.54 | 163,492,770.46 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,804,658.67 | 31,058,941.18 |
| 210104 | Урамшуулал | 25,313,194.84 | 50,007,289.48 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0 | 7,499,712.65 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **62,334,620.36** | **69,288,762.89** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,492,404.32 | 47,228,027.48 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,974,402.60 | 5,556,238.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,976,162.00 | 4,414,190.83 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 990,150.18 | 1,099,118.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,901,501.26 | 10,991,187.25 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **28,998,145.57** | **29,651,746.36** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,619,983.57 | 8,982,243.36 |
| 210302 | Түлш, халаалт | 18,127,784.00 | 15,892,357.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,250,378.00 | 4,777,146.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **34,010,570.00** | **35,196,442.65** |
| 210401 | Бичиг хэрэг | 11,895,750.00 | 12,185,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,399,600.00 | 10,949,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,391,570.00 | 4,741,522.65 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 951,000.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,372,650.00 | 7,079,920.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **13,842,900.00** | **14,039,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 13,544,000.00 | 14,039,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,953,800.00** | **7,265,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,953,800.00 | 7,265,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,440,653.00** | **11,357,125.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,000,000.00 | 10,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 188,853.00 | 159,225.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,200,000.00 | 1,150,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 7,800.00 | 3,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8,586,350.00** | **2,128,500.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,586,350.00 | 2,128,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **38,559,531.25** | **54,159,016.96** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,210,000.00** | **1,950,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,210,000.00 | 1,950,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **37,349,531.25** | **52,209,016.96** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,349,531.25 | 52,209,016.96 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **19,694,600.00** | **19,234,700.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **19,694,600.00** | **19,234,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **19,694,600.00** | **19,234,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **19,694,600.00** | **19,234,700.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 19,694,600.00 | 19,234,700.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-19,694,600.00** | **-19,234,700.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **275,943,025.00** | **30,030,193.52** | **525,991,114.43** | **831,964,332.95** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **275,943,025.00** | **30,030,193.52** | **525,991,114.43** | **831,964,332.95** |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **23,757,122.01** | **23,757,122.01** |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **275,943,025.00** | **30,030,193.52** | **549,748,236.44** | **855,721,454.96** |
| **11** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **275,943,025.00** | **30,030,193.52** | **549,748,236.44** | **855,721,454.96** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **275,943,025.00** | **30,030,193.52** | **549,748,236.44** | **855,721,454.96** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -50,086,977.58 | -50,086,977.58 |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **275,943,025.00** | **30,030,193.52** | **499,661,258.86** | **805,634,477.38** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **813,979,400.00** | **759,870,383.04** | **54,109,016.96** | **93.35** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **813,979,400.00** | **759,870,383.04** | **54,109,016.96** | **93.35** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **810,129,400.00** | **757,920,383.04** | **52,209,016.96** | **93.56** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **602,265,200.00** | **569,758,706.14** | **32,506,493.86** | **94.60** |
| 210101 | Үндсэн цалин | 333,654,000.00 | 317,699,992.37 | 15,954,007.63 | 95.22 |
| 210102 | Нэмэгдэл | 217,754,400.00 | 163,492,770.46 | 54,261,629.54 | 75.08 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 29,256,000.00 | 31,058,941.18 | -1,802,941.18 | 106.16 |
| 210104 | Урамшуулал | 14,100,800.00 | 50,007,289.48 | -35,906,489.48 | 354.64 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,500,000.00 | 7,499,712.65 | 287.35 | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **75,283,100.00** | **69,288,762.89** | **5,994,337.11** | **92.04** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,192,500.00 | 47,228,027.48 | 3,964,472.52 | 92.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,022,700.00 | 5,556,238.56 | 466,461.44 | 92.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,818,100.00 | 4,414,190.83 | 403,909.17 | 91.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,204,500.00 | 1,099,118.77 | 105,381.23 | 91.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,045,300.00 | 10,991,187.25 | 1,054,112.75 | 91.25 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **33,557,000.00** | **29,651,746.36** | **3,905,253.64** | **88.36** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,750,900.00 | 8,982,243.36 | 768,656.64 | 92.12 |
| 210302 | Түлш, халаалт | 18,037,400.00 | 15,892,357.00 | 2,145,043.00 | 88.11 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,768,700.00 | 4,777,146.00 | 991,554.00 | 82.81 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **38,197,700.00** | **35,196,442.65** | **3,001,257.35** | **92.14** |
| 210401 | Бичиг хэрэг | 12,200,000.00 | 12,185,100.00 | 14,900.00 | 99.88 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,949,900.00 | 10,949,900.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,247,800.00 | 4,741,522.65 | 1,506,277.35 | 75.89 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 200,000.00 | 240,000.00 | -40,000.00 | 120.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,600,000.00 | 7,079,920.00 | 1,520,080.00 | 82.32 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **33,273,700.00** | **33,273,700.00** | **0.00** | **100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,436,800.00 | 5,436,800.00 | 0.00 | 100.00 |
| 210602 | Тавилга | 13,797,900.00 | 13,797,900.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,039,000.00 | 14,039,000.00 | 0.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **11,853,000.00** | **7,265,400.00** | **4,587,600.00** | **61.30** |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,853,000.00 | 7,265,400.00 | 4,587,600.00 | 61.30 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,390,700.00** | **11,357,125.00** | **33,575.00** | **99.71** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,000,000.00 | 10,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 188,900.00 | 159,225.00 | 29,675.00 | 84.29 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,150,000.00 | 1,150,000.00 | 0.00 | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 7,800.00 | 3,900.00 | 3,900.00 | 50.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,309,000.00** | **2,128,500.00** | **2,180,500.00** | **49.40** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,309,000.00 | 2,128,500.00 | 2,180,500.00 | 49.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,850,000.00** | **1,950,000.00** | **1,900,000.00** | **50.65** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,850,000.00** | **1,950,000.00** | **1,900,000.00** | **50.65** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,850,000.00 | 1,950,000.00 | 1,900,000.00 | 50.65 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **813,979,400.00** | **759,870,383.04** | **54,109,016.96** | **93.35** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **813,979,400.00** | **759,870,383.04** | **54,109,016.96** | **93.35** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 813,979,400.00 | 759,870,383.04 | 54,109,016.96 | 93.35 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **-** | **100.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **23** | **21** | **2** | **91.30** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 8 | 7 | 1 | 87.50 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 14 | 13 | 1 | 92.86 |

68

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Прокурорын газар /*Аймгийн Прокурорын газар*/ нь "*Хууль тогтоох байгууллагын бодлогын үзэл санааг туушгай дэмжиж, хяналтын ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх, зон олны эрх, эрх чөлөө, эд баялаг, түүхт уламжлалыг сахин хамгаалж, хууль тогтоомжийг төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх*" гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагаанд инновац нэвтрүүлэх,
- Гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах,
- Прокурор, ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх,
- Чадварлаг прокурор, ажилтныг сайшаан дэмжих,
- Прокурор, ажилтны суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Аймгийн Прокурорын газрын санхүүгийн үйл ажиллагаанд УЕПГ-ын Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын хэлтсээс хяналт тавьж ажилладаг бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Прокурорын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

МУЕП-ын 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/125 дугаар тушаалаар МУПЕГ болон түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Прокурорын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан *"Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"*-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,086.9 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 20,500.61 | 14,279.96 | -6,220.65 |
| Үндсэн хөрөнгө | 835,220.84 | 791,354.51 | -43,866.33 |
| **Нийт хөрөнгө** | **855,721.45** | **805,634.47** | **-50,086.98** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 855,721.45 | 805,634.47 | -50,086.98 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **855,721.45** | **805,634.47** | **-50,086.98** |

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Бараа материал дансны үлдэгдэл нь 14,279.9 мянган төгрөг болж, 6,220.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 52,730.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 58,951.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 791,354.5 мянган төгрөг болж, 43,866.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 19,234.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авч, УЕПГ-аас 6,547.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр орлого авч, 69,648.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 911,280.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 204,932.7 мянган төгрөгөөр бууруулж */ бараа, үйлчилгээний бусад зардлыг 53,819.3 мянган төгрөгөөр, цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 51,825.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 29,920.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 26,140.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 20,436.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 18,262.2 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна./* 706,347.3 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг нийт 107,632.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн тодотгол, зохицуулалт хийж, 813,979.4 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- *Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 63,113.4 мянган төгрөгөөр,*
- *Эд хогшил, урсгал засварын зардлыг 12,073.7 мянган төгрөгөөр,*
- *Тогтмол зардлыг 9,733.1 мянган төгрөгөөр,*
- *Хангамж, бараа материалын зардлыг 8,549.9 мянган төгрөгөөр гэх мэт.*

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 813,979.4 мянган төгрөгийн төсөв батлаж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 812,079.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 759,870.4 мянган төгрөг буюу 93.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 54,109.0 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 800,129.40 | 747,920.40 | 52,209.00 | 93.47 |
| 2 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 3,850.00 | 1,950.00 | 1,900.00 | 50.65 |
| 3 | Байцаан шийтгэх ажиллагаа | 10,000.00 | 10,000.00 | 0.00 | 100.00 |
| | **Дүн** | **813,979.40** | **759,870.40** | **54,109.00** | **93.35** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "*нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна*" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130006401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн тухайн жилийн төсвийн төлөвлөгөөнд "Ахмадын сан"-ийн зардлыг тусган, батлуулах, бараа материалыг зарцуулахдаа тухай бүр эд хариуцагч, албан хаагч тус бүрээр шаардах хуудас үйлдүүлж, холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл авсны дараа олгож байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Прокурорын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1/103 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 772,716.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,727.2 мянган

төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллага нь тайлант онд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг хэмнэсэн,
- Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилал, төрсөн нутагтаа амрах тохиолдолд очих, ирэх замын зардлыг олгоогүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Байгууллагын дулаан, цахилгааны хэрэглээнд албан хаагчдыг хэмнэлттэй байх үүрэг даалгавар өгч, үр ашиггүй зардал гаргахгүй ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Аймгийн Прокурорын газрын мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

73

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлээгүй зөрчилд зөвлөмж өгснийг дахин давтан гаргаагүй байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 6,058.6 | 1 | 6,058.6 | 100 |
| **Нийт дүн** | **1** | **6,058.6** | **1** | **6,058.6** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **21,068.0** мянган төгрөгийн зөрчил илэрч, 2 зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь *"... байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах ..."*, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.3 дахь "*Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана*" гэсэн заалтын дагуу Ахмадын сангийн эх үүсвэрийг төсөвт тусган төлөвлөөгүйгээс жилийн эцэст цалингийн зардлаас **18,068.0** мянган төгрөгийг УЕПГ-ын 2102983685 дугаар дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх *"Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална"*, 5.1.2 дахь *"Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалтыг хэрэгжүүлэн тухайн жилийн төсвийн төлөвлөгөөнд *"Ахмадын сан"*-ийн зардлыг тусган, батлуулах.

**2.Бараа материалын зарцуулалттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас худалдан авсан 3,000.0 мянган төгрөгийн тараах материалын зарцуулалтын шаардах хуудсыг тухай бүр бус бөөн дүнгээр бичиж, зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дахь *“Аж ахуйн нэгж, байгууллагын ... нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн* ***хөдлөл, өөрчлөлт бүрийг*** *анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.6: " *Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд* ***зарцуулах шаардлага гарсан үед*** *уг зүйлийг авч зарцуулах хүн "Шаардах хуудас"-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч* ***шаардах хуудсыг үндэслэн*** *материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ." гэсэн* заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Бараа материалыг зарцуулах тухай бүр шаардах хуудас бичиж холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл авсны дараа олгож байх.

Дээрх ***зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг*** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[1]-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

[1] *Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаал-тны тоо | Тоо | Дүн |
| Ахмадын сангийн хөрөнгийг төлөвлөөгүй. | 1 | 18,068.0 | | | | | 1 | 18,068.0 | | | | |
| Бараа материалын шаардах хуудсыг тухай бүр хөтлөөгүй. | 1 | 3,000.0 | | | | | 1 | 3,000.0 | | | | |
| **Дүн** | **2** | **21,068.0** | | | | | **2** | **21,068.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |